

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/151/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn  
Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК  
захирал: С.Оюунгэрэл

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/92

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА П.ЛХАГВАДУЛАМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийн хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой мөнгөн хөрөнгийн данс 939.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Баянхангай сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 42,736.4 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

019800102

Эргэлтийн эмийн сан нь байрны түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууныг зарцуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд 3 хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж эрүүл мэндийн газраар 99,4 хувьтай дүгнэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>93,765,646.73</b>	<b>77,871,153.74</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	30,792,868.82	939,385.98
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	30,792,868.82	939,385.98
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	30,792,868.82	939,385.98
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	7,287,684.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	7,287,684.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	62,972,777.91	69,644,083.76
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	42,278,869.29	45,658,138.14
35130	Эм боох материал	42,278,869.29	45,658,138.14
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,693,908.62	23,985,945.62
35410	Бичиг хэргийн материал	247,500.00	714,000.00
35420	Аж ахуйн материал	13,460,255.00	16,897,355.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,000,000.00
35460	Хүнсний материал	2,796,695.00	2,185,132.00
35470	Бусад хангамжийн материал	3,189,458.62	3,189,458.62
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>354,504,388.97</b>	<b>457,269,862.33</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	354,504,388.97	457,269,862.33
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	345,856,388.97	448,621,862.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	261,695,947.69	261,695,947.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,198,219.52	-32,747,774.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,540,000.00	169,540,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,640,000.00	-40,240,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,147,874.99	162,066,210.99
39206	Хуримтлагдсан элэгдэл	-69,947,447.73	-90,474,457.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,418,144.50	31,418,144.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,159,910.96	-12,636,209.16
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,648,000.00	8,648,000.00
39301	Програм хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-850,000.00	-850,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,648,000.00	8,648,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>448,270,035.70</b>	<b>535,141,016.07</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>19,660,000.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	19,660,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	19,660,000.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,660,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>428,610,035.70</b>	<b>535,141,016.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	428,610,035.70	535,141,016.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,542,458.80	126,542,458.80
51101	Өмч: - төрийн	126,542,458.80	126,542,458.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	295,071,691.46	401,602,671.83

51210	Өмнөх үеийн үр дүн	295,071,691.46	295,071,691.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	106,530,980.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,995,885.44	6,995,885.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>448,270,035.70</b>	<b>535,141,016.07</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>440,592,818.02</b>	<b>609,611,713.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>62,598,818.02</b>	<b>154,233,054.83</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	62,598,818.02	154,233,054.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,578,818.02	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,578,818.02	00.00
120009	Бусад орлого	20,000.00	00.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	00.00	132,487,279.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	21,745,775.83
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>377,994,000.00</b>	<b>455,378,658.38</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	19,293,900.00	26,223,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,293,900.00	26,223,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	358,450,100.00	428,155,358.38
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	358,450,100.00	428,155,358.38
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>483,976,165.61</b>	<b>503,080,732.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>483,976,165.61</b>	<b>503,080,732.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	482,223,748.98	503,080,678.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	278,746,691.65	315,892,144.72
210101	Үндсэн цалин	179,043,180.28	211,568,975.98
210102	Нэмэгдэл	76,690,703.73	73,695,405.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,540,000.00	2,925,800.00
210104	Урамшуулал	19,472,807.64	27,701,963.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,494,376.60	39,418,900.00
210201	Тэтгэврийн даатгал	26,328,276.60	26,804,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,541,500.00	3,152,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,300.00	2,523,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508,300.00	631,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,083,000.00	6,307,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,273,840.37	22,923,245.68
210301	Гэрэл, цахилгаан	2,806,819.57	3,611,345.92
210302	Түлш, халаалт	14,147,020.80	19,101,899.76
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	210,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,244,658.00	23,590,384.50
210401	Бичиг хэрэг	2,321,700.00	1,284,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,425,608.00	14,873,784.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,300.00	1,468,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,542,050.00	5,204,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,458,000.00	758,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	74,973,317.85	45,389,437.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,208,572.85	37,343,474.98
210502	Хоол, хүнс	7,764,745.00	8,045,963.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,031,300.00	3,970,000.00
210604	Урсгал засвар	2,031,300.00	3,970,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.00	1,760,900.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,760,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,450,000.00	1,304,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,450,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	172,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	44,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	512,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,509,564.51	48,830,805.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,005,210.00	9,088,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,504,354.51	39,742,805.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,752,416.63	54.32
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	832,357.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	832,357.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	920,059.63	54.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	920,059.63	54.32
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-43,383,347.59</b>	<b>106,530,980.37</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-43,383,347.59</b>	<b>106,530,980.37</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>475,750,500.00</b>	<b>428,430,974.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,000.00	00.00
120009	Бусад орлого	20,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>475,730,500.00</b>	<b>428,430,974.38</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	1,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>19,293,900.00</b>	<b>26,223,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,293,900.00	26,223,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>456,186,600.00</b>	<b>401,207,674.38</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	456,186,600.00	401,207,674.38
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>466,468,186.75</b>	<b>448,263,457.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>466,468,186.75</b>	<b>448,263,457.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>464,715,770.12</b>	<b>448,263,402.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>278,746,691.65</b>	<b>315,892,144.72</b>
210101	Үндсэн цалин	179,043,180.28	211,568,975.98
210102	Нэмэгдэл	76,690,703.73	73,695,405.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,540,000.00	2,925,800.00
210104	Урамшуулал	19,472,807.64	27,701,963.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,494,376.60</b>	<b>39,418,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,328,276.60	26,804,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,541,500.00	3,152,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,300.00	2,523,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508,300.00	631,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,083,000.00	6,307,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,273,840.37</b>	<b>22,923,245.68</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,806,819.57	3,611,345.92
210302	Түлш, халаалт	14,147,020.80	19,101,899.76
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	210,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,644,408.00</b>	<b>20,929,584.50</b>
210401	Бичиг хэрэг	2,199,100.00	1,498,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,425,608.00	14,873,784.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,300.00	1,918,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,522,400.00	2,639,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39,934,143.50</b>	<b>28,590,368.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,176,343.50	19,200,968.00
210502	Хоол, хүнс	7,757,800.00	7,434,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>50,542,400.00</b>	<b>7,002,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,375,000.00	225,000.00
210602	Тавилга	7,656,700.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,050,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,460,700.00	6,777,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,760,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,760,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,450,000.00</b>	<b>1,142,260.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,450,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	172,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	44,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,129,910.00</b>	<b>10,604,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,129,910.00	10,604,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,752,416.63</b>	<b>54.32</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>832,357.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	832,357.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>920,059.63</b>	<b>54.32</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	920,059.63	54.32
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,282,313.25</b>	<b>-19,832,482.84</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>10,021,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>10,021,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>10,021,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,021,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-10,021,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>9,282,313.25</b>	<b>-29,853,482.84</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>21,510,555.57</b>	<b>30,792,868.82</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>30,792,868.82</b>	<b>939,385.98</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	338,455,039.05	471,993,383.29
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-43,383,347.59	-43,383,347.59
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	295,071,691.46	428,610,035.70
D01	2023 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	295,071,691.46	428,610,035.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	295,071,691.46	428,610,035.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	106,530,980.37	106,530,980.37
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,542,458.80	6,995,885.44	401,602,671.83	535,141,016.07

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	573,623,600.00	458,284,402.90	115,339,197.10	79.89
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	573,623,600.00	458,284,402.90	115,339,197.10	79.89
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	573,623,600.00	458,284,402.90	115,339,197.10	79.89
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	394,335,800.00	315,892,144.72	78,443,655.28	80.11
210101	Үндсэн цалин	296,478,400.00	211,568,975.98	84,909,424.02	71.36
210102	Нэмэгдэл	48,997,000.00	73,695,405.28	-24,698,405.28	150.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,351,600.00	2,925,800.00	425,800.00	87.30
210104	Урамшуулал	45,508,800.00	27,701,963.46	17,806,836.54	60.87
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,974,500.00	39,418,900.00	1,555,600.00	96.20
210201	Тэтгэврийн даатгал	27,861,900.00	26,804,100.00	1,057,800.00	96.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,277,200.00	3,152,800.00	124,400.00	96.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,622,900.00	2,523,300.00	99,600.00	96.20
210204	Ажилгүйдлийн даатгал	656,100.00	631,200.00	24,900.00	96.20
210205	Эрүүл мэндийн даатгал	6,556,400.00	6,307,500.00	248,900.00	96.20
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,395,300.00	22,923,245.68	2,472,054.32	90.27

210301	Гэрэл, цахилгаан	5,729,900.00	3,611,345.92	2,118,554.08	63.03
210302	Түлш, халаалт	19,345,400.00	19,101,899.76	243,500.24	98.74
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	210,000.00	110,000.00	65.63
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,415,300.00</b>	<b>20,929,584.50</b>	<b>2,485,715.50</b>	<b>89.38</b>
210401	Бичиг хэрэг	1,500,300.00	1,498,000.00	2,300.00	99.85
210402	Тээвэр, шатахуун	16,040,000.00	14,873,784.50	1,166,215.50	92.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,300.00	1,918,800.00	81,500.00	95.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,874,700.00	2,639,000.00	1,235,700.00	68.11
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,708,500.00</b>	<b>28,590,368.00</b>	<b>7,118,132.00</b>	<b>80.07</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,379,500.00	19,200,968.00	5,178,532.00	78.76
210502	Хоол, хүнс	9,329,000.00	7,434,400.00	1,894,600.00	79.69
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,955,000.00	45,000.00	97.75
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,282,900.00</b>	<b>17,023,000.00</b>	<b>6,259,900.00</b>	<b>73.11</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,700,000.00	10,246,000.00	1,454,000.00	87.57
210604	Урсгал засвар	11,582,900.00	6,777,000.00	4,805,900.00	58.51
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,874,700.00</b>	<b>1,760,900.00</b>	<b>113,800.00</b>	<b>93.93</b>
210702	Дотоод албан томилолт	1,874,700.00	1,760,900.00	113,800.00	93.93
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,450,000.00</b>	<b>1,142,260.00</b>	<b>307,740.00</b>	<b>78.78</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	624,000.00	576,000.00	48,000.00	92.31
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	172,260.00	177,740.00	49.22
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	126,000.00	44,000.00	82,000.00	34.92
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	350,000.00	350,000.00	00.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,186,600.00</b>	<b>10,604,000.00</b>	<b>16,582,600.00</b>	<b>39.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,186,600.00	10,604,000.00	16,582,600.00	39.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>521,830,700.00</b>	<b>427,430,974.38</b>	<b>94,399,725.62</b>	<b>81.91</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>32,345,300.00</b>	<b>26,223,300.00</b>	<b>6,122,000.00</b>	<b>81.07</b>
132001	Орон нутгийн төсвөөс	32,345,300.00	26,223,300.00	6,122,000.00	81.07
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>489,485,400.00</b>	<b>401,207,674.38</b>	<b>88,277,725.62</b>	<b>81.97</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	489,485,400.00	401,207,674.38	88,277,725.62	81.97
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	00.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>139,515,156.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>139,515,156.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>122,507,156.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>13,693,653.81</b>
210102	Нэмэгдэл	13,693,653.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,167,264.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	793,739.00
210202	Тэтгэмжийн даатгал	93,381.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,705.00
210204	Ажилгүйдлийн даатгал	18,677.00
210205	Эрүүл мэндийн даатгал	186,762.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>729,400.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	729,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,269,930.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,732,010.00
210502	Хоол, хүнс	5,537,920.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>48,883,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,289,900.00
210602	Тавилга	1,956,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,785,000.00
210604	Урсгал засвар	1,852,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,763,809.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,763,809.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,008,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,008,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,008,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхангай сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тус байгууллагын зорилго нь Сумын хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, бие бялдрын өв тэгш хөгжлийг хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг:

- ✓ Ёс зүйтэй орчинд
- ✓ Цаг алдалгүй
- ✓ Жигд хүртээмжтэй
- ✓ Чанартай
- ✓ Соёлтой үзүүлэхэд бидний эрхэм зорилго оршино.

Эрхэм зарчим нь: Энэхүү зорилгыг хангаж ажиллахын тулд дараах үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

- ✓ Үйлчлүүлэгчээ дээдэлнэ
- ✓ Эмнэлгийн эмч , мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахина.
- ✓ Хариуцлага хүлээх ёстой : Сумын ард түмний эрүүл мэндийн төлөө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж ажиллана.
- ✓ Шударга ёс : Төрийн хууль ёс , хэм хэмжээг чанд сахиж , албан үүргээ үнэнч шударгаар биелүүлнэ.
- ✓ Найдвартай байдал: Мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж , багаар ажиллан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхангай сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д "Хот суурийн газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ" үзүүлдэг Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх; сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх; сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээн

- ✓ Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,870.9 мянган төгрөг буюу 16,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,792.87	939.38	(29,853.49)
Авлага		7,287.68	7,287.68
Урьдчилгаа			-
Бараа материал	62,972.77	69,644.08	6,671.31
Үндсэн хөрөнгө	354,504.39	457,269.86	102,765.47
<b>Нийт хөрөнгө</b>	<b>448,270.03</b>	<b>535,141.01</b>	<b>86,870.98</b>
Өр төлбөр	19,660.00		(19,660.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	126,542.46	126,542.46	-
Хуримтлагдсан үр дүн	295,071.69	401,602.67	106,530.98
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,995.88	6,995.88	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>448,270.03</b>	<b>535,141.01</b>	<b>86,870.98</b>

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Авлагын дансны үлдэгдэл 7,287.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн нийгмийн даатгалын хэлтсээс авлага үүссэн байна.

Бараа материал 6,671.3 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материал дээр нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 102,765.47 мянган төгрөгөөр өссөн нь 120,000.0 мянган төгрөгөөр авто тээврийн хэрэгсэл хандиваар нэмэгдсэн.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 19,660.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эхэнд санхүүжилтийн 19,660.0 төгрөг тайлант онд барагдуулсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл улсын төсвөөс 220,297.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 174,245.8 мянган төгрөг, нийт зарлагыг 394,542.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 394,542.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 349,343.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 140,142.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан хөрөнгө арга

---

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Худалдан авах ажиллагаанд 18 ажил үйлчилгээний 113,499.6 мянган төгрөгийн төлөвлөгөө батлуулснаас 89,970.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаа. Хэмнэгдсэн шалтгаан нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлийн санхүүжилт авч чадаагүй улмаас дутуу зарцуулагдсан.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Д.Энх-Амгалан, Ө.Бат-Оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 425,170.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,377.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,783.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 4 мэдээлэл, 6 мэдээлэл байршуулаагүй байгаа нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байна. Монгол Эм Импекс Концерн ХХК-д мөнгөн хөрөнгөөс 5,527.5 мянган төгрөг шилжүүлсэн боловч шилэн дансанд мэдээлээгүй, Хангайн Цогт Илч ХХК-д мөнгөн хөрөнгөөс 19,101.8 мянган төгрөг шилжүүлсэн боловч 4,775.2 мянган төгрөг дутуу шилэн дансанд мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 42,736.4 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.2 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Баянхангай сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д "иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх", 1.2-т "хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх", 1.3-д "татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх", 2-т "Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ", 2.1-д "хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх", 2.2-т "тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах", 2.3-д "хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх", 2.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах", 2.5-д "зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх", 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Баянхангай сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна", 21 дүгээр зүйлд "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн татварын тухай, Төсвийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 8 зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	288.0	1	288.0	100,0
Албан шаардлага	2	15,997.6	2	15,997.6	100,0
Зөвлөмж	1	22,974.7	1	0.00	0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>39,260.3</b>	<b>4</b>	<b>16,285.0</b>	<b>66,6</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39,260.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 288.0 төгрөгийн актыг бүрэн барагдуулж, 15,997.6 мянган төгрөгийн албан шаардлага хэрэгжсэн, 22,974.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс цахим баримтыг худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх, нормативт зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, албан бичгээр харилцдаг эсэхийг авч үзэх.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 99,616.6 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 8,538.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 91,078.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны баримтаар баталгаажуулаагүй 8,538.0 мянган төгрөгөөр дутуу хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг

таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Байгууллагын 101 нэр төрлийн 91,019.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн байгаа нь хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийн тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д “Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм”, 6.13-д “Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр, үнэн зөв бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

#### **2. Өглөгийн данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Татварын цахим тайлангийн системээр зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр нийт 59.8 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг үүсгэхгүй, тулган баталгаажуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримт 8,538.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	8,538.0			1	8,538.0						
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 101 нэр төрлийн 91,019.0 мянган төгрөгийн биет хөрөнгө бүртгэлтэй байна	1	91,019.0					1	91,019.0				
Зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр нийт 59.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байна	1	59.5					1	59.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>99,616.6</b>			<b>1</b>	<b>8,538.0</b>	<b>2</b>	<b>91,078.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хугацаа хоцорсон 4 мэдээлэл, мэдээлээгүй 6 мэдээлэл байршуулсан байна.	1				1			
10,302.7 мянган төгрөг дутуу шилэн дансанд мэдээлсэн байна.	1	10,302.7			1	10,302.7		
Дүн	2	10,302.7			2	10,302.7		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 42,736.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	42,736.4					1	42,736.4
Эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг	1						1	
Түрээсийн орлого төвлөрүүлээгүй, ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан	1						1	
Дүн	3	42,736.4					3	42,736.4
Нийт дүн	3	53,039.1			2	10,302.7	3	42,736.4

